Хорооны дарга Б.Мөнхзул	Засаглал, нэр дэвшүүлэх хороо нь компанийн засаглалын бүтэц, ТУЗ-ийн үйл ажиллагаа холбогдох хууль, дүрэм, журмын шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийж, ТУЗ болон удирдах албан тушаалтнуудын томилгоо, чөлөөлөлттэй холбоотой асуудлаар санал, дүгнэлт боловсруулсан. Түүнчлэн ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээ, чадавх хөгжүүлэх чиглэлд анхаарч, сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан ажилласан.
Хорооны гишүүн Сиваев А.В.	
Хорооны гишүүн Л.Таня	
Цалин урамшууллын хороо	
Хорооны дарга Сиваев А.В.	Цалин, урамшууллын хороо нь удирдах албан тушаалтнуудын цалин, урамшууллын бодлогын хэрэгжилтийг хэлэлцэж, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулах талаар санал гаргасан. Мөн гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцооны хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийж, ил тод, шударга, гүйцэтгэлтэй уялдсан бодлогыг цаашид сайжруулах шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлсон.
Хорооны гишүүн Б.Мөнхзул	
Хорооны гишүүн И.Дариймаа	
Эрсдэл, даатгалын эрсдэлийн хороо	
Хорооны дарга Громов С.Б.	Эрсдэл, даатгалын эрсдэлийн хороо нь компанийн даатгалын үндсэн эрсдэл, санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн чадварт нөлөөлөх эрсдэлүүдийг тогтмол хэлэлцсэн. Давхар даатгалын бодлого, эрсдэлийн хуваарилалт, багцын зохистой байдлын талаар дүгнэлт гаргаж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаар бодитой санал, зөвлөмжийг ТУЗ-д хүргүүлсэн. Мөн өндөр дүнтэ нөхөн төлбөрийн асуудлуудыг шийдвэрлэж ажилласан.
Хорооны гишүүн Огай Н.Ю.	
Хорооны гишүүн Л.Таня	

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

№	Үзүүлэлт	Дундаж оноо	Санал тайлбар
1	Үндсэн чиг үүргийн хэрэгжилт	4	ТУЗ нь хууль, дүрэм, журмын хүрээнд компанийн стратеги, санхүүгийн тогтвортой байдал, эрсдэлийн удирдлагад чиглэсэн үндсэн чиг үүргээ нийтэд нь хангалттай хэрэгжүүлж ажилласан. Цаашид стратегийн зорилтын хэрэгжилтийн хяналтыг илүү хэмжигдэхүйц үзүүлэлтээр үнэлэх шаардлагатай.
2	ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн	5	ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь даатгал, санхүү, хууль, удирдлагын мэргэжлийн тэнцвэртэй оролцоотой, хараат бус гишүүдийн шаардлагыг хангасан байна. Компанийн засаглалын сайн туршлагад бүрэн нийцэж байна.
3	ТУЗ-ийн ажлын зохион байгуулалт	4	ТУЗ-ийн хуралдаан тогтмол, хэлэлцэх асуудал тодорхой, баримт материалын бэлтгэл хангалттай түвшинд байна. Цаашид хуралдааны дараах шийдвэрийн хэрэгжилтийн хяналтыг сайжруулах боломжтой.
4	ТУЗ-ийн дарга	5	ТУЗ-ийн дарга хуралдааныгүр дүнтэй удирдан зохион байгуулж, гишүүдийн санал бодлыгтэнцвэртэй тусган, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын уялдаа холбоог өндөр түвшинд хангаж ажилласан.
5	ТУЗ-ийн дэргэдэх хороодын үнэлгээ	3	Хороодын үйл ажиллагаа зохион байгуулагдаж байгаа боловч хуралдааны давтамж, гаргасан дүгнэлт, зөвлөмжийн ТУЗ-д нөлөөлөх байдал хангалтгүй байна. Хороодын ажлын төлөвлөгөө, тайлагналтыг сайжруулах шаардлагатай.
6	Аудитын хороо	4	Санхүүгийн тайлагнал, дотоод хяналт, аудитын асуудлыг тогтмол хэлэлцэж, зохих дүгнэлт гаргаж ажилласан. Цаашид дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд илүү анхаарах шаардлагатай.
7	Цалин урамшууллын хороо	3	Цалин, урамшууллын бодлогын хүрээнд үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байгаа боловч гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоог илүү нарийвчлан боловсруулах шаардлагатай.
8	Нэр дэвшүүлэх хороо	4	ТУЗ-ийн гишүүд, удирдах ажилтны томилгоотой холбоотой санал, дүгнэлтийг дүрэм журмын дагуу гаргаж ажилласан. Цаашид залгамж халааны бодлогыг илүү тодорхой болгох боломжтой.
9	Эрсдэл, даатгалын хороо	5	Даатгалын үндсэн эрсдэл, төлбөрийн чадвар, давхар даатгал, эрсдэлийн удирдлагын асуудлыг идэвхтэй хэлэлцэж, ТУЗ-д бодитой санал, зөвлөмж хүргүүлсэн нь өндөр үнэлгээ авсан.

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН АЖЛЫН ҮНЭЛГЭЭ

№	ТУЗ-ийн гишүүний овог нэр	Дундаж оноо	Санал тайлбар
1	Громов Сергей Борисович	5	Даатгал, санхүүгийн салбарын туршлагад тулгуурлан стратегийн түвшинд идэвхтэй санал дэвшүүлж, ТУЗ-ийн шийдвэр гаргалтад бодитой хувь нэмэр оруулсан.
2	Сиваев Александр Владимирович	4	Хуралдаанд тогтмол оролцож, мэргэжлийн дүгнэлт гаргадаг. Цаашид стратегийн хэлэлцүүлэгт оролцоогоо нэмэгдүүлэх боломжтой.
3	Батмөнхийн Мөнхзул	5	Комплайнс, засаглал, эрсдэлийн асуудалд идэвхтэй оролцож, компанийн үйл ажиллагааг сайжруулахад үр нөлөөтэй санал гаргасан.
4	Ишхүүгийн Дариймаа	-	Томилогдсон хугацаа богино тул тайлант хугацаанд үнэлгээ хийгдээгүй болно.
5	Жамбалын Эрдэнэтуяа	-	Томилогдсон хугацаа богино тул тайлант хугацаанд үнэлгээ хийгдээгүй болно.
6	Лизунова Таня	5	Санхүү, аудитын чиглэлээр мэргэжлийн өндөр түвшний дүгнэлт өгч, ТУЗ-ийн хяналтын чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулсан.
7	Огай Наталья Юрьевна	5	Эрсдэл, даатгалын асуудалд сайн оролцож, бодлогын түвшний санал зөвлөмж тогтмол гаргасан.
8	Энхсайханы Алтанзул	4	Хуралдаанд идэвхтэй оролцож, салбарын онцлогт нийцсэн санал дэвшүүлдэг.
9	Эрсдэл, даатгалын хороо Гэндэнпилийн Батдорж	-	Томилогдсон хугацаа богино тул тайлант хугацаанд үнэлгээ хийгдээгүй болно.

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## ДҮГНЭЛТ

№	ТУЗ болон хороодын давуу талууд	ТУЗ болон хороодын сул талууд	ТУЗ болон хороодын үйл ажиллагааны тулгамдаж буй асуудлууд	Цаашид сайжруулах үндсэн чиглэл, арга хэмжээнүүд
1	Компанийн засаглал, комплайнс, эрсдэлийн удирдлагын тогтолцоог ТУЗ-ийн түвшинд хангаж ажилладаг	Зарим хороодын хуралдааны давтамж, идэвх харьцангуй сул	Хороодын гаргасан санал, дүгнэлт ТУЗ-ийн шийдвэрт бүрэн тусахгүй байх	Хороодын ажлын төлөвлөгөө, хуралдааны давтамжийг жил бүр баталж мөрдүүлэх
2	Эрсдэл, даатгалын хороо салбарын онцлог эрсдэлийг идэвхтэй хянаж ажилладаг	Хороодын тайлан, дүгнэлтийн агуулга жигд бус	Тайлагналын нэгдсэн стандарт, хэлбэр дутмаг	Хороодын тайлангийн нэгдсэн загвар, шалгуур батлах
3	Аудитын хороо санхүү, дотоод хяналтын асуудлыг тогтмол хэлэлцдэг	Зарим гишүүдийн оролцоо, бэлтгэл хангалтгүй	Шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийн хяналт сул	Шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог сайжруулах
4	ТУЗ-ийн даргын манлайлал, зохион байгуулалт сайн	Цалин урамшууллын хороо гүйцэтгэлд суурилсан үнэлгээг бүрэн хэрэгжүүлээгүй	Урамшууллын бодлого гүйцэтгэлтэй бүрэн уялдаагүй	Гүйцэтгэлд суурилсан урамшууллын бодлогыг шинэчлэх
5	Хууль, зохицуулалтын шаардлагыг мөрдөн ажилладаг	Нэр дэвшүүлэх, залгамж халааны бодлогыг сайжруулах шаардлагатай	Ирээдүйн удирдлагын залгамж халааг системтэй төлөвлөөгүй	Залгамж халаа, гишүүдийн чадавх хөгжүүлэх бодлого боловсруулах

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Улирал	Сэдэв	Зорилго	Хэлбэр	Биелэлтийн үнэлгээ	Тайлбар
I улирал	Компанийн засаглал	Компанийн засаглалын зарчим, үүрэг хариуцлагыг бататгах	Танхим	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн гишүүд бүрэн хамрагдсан
I улирал	Хууль эрх зүйн зохицуулалт	Даатгалын хууль, зохицуулалтын шинэчлэлтэй танилцах	Танхим/Вебинар	Бүрэн хэрэгжсэн	Шинэчлэгдсэн мэдээлэл олгосон
II улирал	Даатгалын салбарын чиг хандлага	Салбарын шинэ чиг хандлага, боломжийг судлах	Вебинар/Кейс судлал	Бүрэн хэрэгжсэн	Кейс судалгаа хийсэн
II улирал	Эрсдэлийн удирдлагын тогтолцоо	Санхүү болон үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх	Семинар, хэлэлцүүлэг	Хэсэгчлэн хэрэгжсэн	Практик кейс нэмэх шаардлагатай
III улирал	Захирлуудад зориулсан санхүүгийн мэдлэг	Санхүүгийн тайлан, үзүүлэлтийн ойлголтыг нэмэгдүүлэх	Танхим	Бүрэн хэрэгжсэн	Санхүүгийн тайлан унших чадвар сайжирсан
III улирал	ESG ба Тогтвортой байдал	ESG-ийг шийдвэр гаргалтад тусгах	Танхим/Вебинар	Хэсэгчлэн хэрэгжсэн	Практик хэрэгжилтийн жишээ шаардлагатай
IV улирал	Стратеги төлөвлөлт ба хяналт	Стратегийн хяналт, шийдвэр гаргалтыг сайжруулах	Танхим	Бүрэн хэрэгжсэн	Стратегийн хэрэгслүүдийг танилцуулсан
IV улирал	ТУЗ-ийн үнэлгээ	ТУЗ-ийн гүйцэтгэл, сайжруулах чиглэлийг үнэлэх	Хэлэлцүүлэг	Бүрэн хэрэгжсэн	Сайжруулах чиглэлүүд тодорхойлогдсон

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЖЛЫН ТАЙЛАН

### 1. ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах

ТУЗ нь 2025 онд нийт 4 удаа биечлэн, эчнээ хэлбэрээр 13 удаа тус тус хуралдаж, нийт 49 шийдвэр гаргасан бөгөөд эдгээр хурлуудын бэлтгэл зохион байгуулалт, хурлаар хэлэлцэх асуудлын танилцуулга бэлтгэх, хурлаас гарах шийдвэрийн төслийг боловсруулах, ТУЗ-ийн гишүүдэд хэлэлцэх асуудлын тухай мэдээлэл, баримт материалыг цаг тухай бүрт нь хариуцлагатайгаар хүргэх, мэдээлэх үүргээ хэрэгжүүлэн ажилласан.

### 2. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо, засаглал, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороо, эрсдэл, даатгалын эрсдэлийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулалтын хувьд дэмжиж, хуралдаан зохион байгуулах, материал бэлтгэх, гаргасан дүгнэлт, зөвлөмжийг ТУЗ-д танилцуулах ажлыг ханган ажилласан.

### 3. ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон оролцогч талуудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хувьцаа эзэмшигчид, олон нийтэд хүргэх

"Монгол Даатгал" ХК-ийн үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээлэл, Төлөөлөн Удирдах Зөвлөл, түүний дэргэдэх хороодын бүтэц зохион байгуулалт, тэдгээрийн шийдвэр, батлагдсан дүрэм журам, шинэчлэлт, өөрчлөлт, нэмэлт мэдээллийг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаст цаг тухай бүрт нь оруулж ажилласан. Мөн "Монгол Даатгал" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр биечлэн зохион байгуулж, хурлыг "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын дагуу амжилттай зохион байгуулж, хурлын талаархи мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээлсэн. Тус хурлын тайланг хуулийн хугацаанд бэлтгэж Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Бирж тус бүрт илгээсэн.

### 4. Хууль, засаглалын хэрэгжилт

Компанийн тухай хууль, даатгалын салбарын хууль тогтоомж, компанийн дүрэм, дотоод журам, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам зэрэг баримт бичгийн хэрэгжилтийг хангах чиглэлд хяналт тавьж, зөрчил, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгэлээ. ТУЗ-ийн гишүүдэд хууль, зохицуулалтын шинэчлэлтэй холбоотой мэдээллийг тухай бүрд нь хүргүүлж ажилласан.

### 5. Баримт бичиг, тайлагнал

ТУЗ-ийн НБД нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын тогтоол, шийдвэр, протокол, холбогдох баримт бичгийг архивлах, хадгалах, бүртгэлжүүлэх ажлыг журамд нийцүүлэн хийж, ТУЗ-ийн тайлан, засаглалын тайлан, сургалт, үнэлгээтэй холбоотой мэдээллийг нэгтгэн боловсруулсан. Мөн Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох байгууллагад хүргүүлэх тайлан, мэдээллийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлсэн.

### 6. Сургалт, чадавх хөгжүүлэлт

ТУЗ-ийн гишүүдийн сургалт, чадавх хөгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, сургалтын биелэлтийн тайлан, нэгдсэн дүгнэлтийг боловсруулан ТУЗ-д танилцуулсан. Сургалтын хэрэгжилт нь ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн.

### 7. Дүгнэлт

Тайлант хугацаанд ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагааг зохион байгуулалтын хувьд бүрэн дэмжиж, компанийн засаглалын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн үүргээ зохих түвшинд хэрэгжүүлсэн гэж дүгнэж байна. Цаашид ТУЗ-ийн үйл ажиллагааны ил тод байдал, тайлагнал, үнэлгээ болон сургалтын тогтолцоог улам боловсронгуй болгох чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай.

Тайлан бэлтгэсэн:  
ТУЗ-ийн НБД Т.Цацрал

Танилцсан:  
ТУЗ-ийн дарга Громов С.Б.

## ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА



Эцэг /эх/-ийн нэр:

**Громов**

Өөрийн нэр:

**СЕРГЕЙ БОРИСОВИЧ**

Төрсөн он: **1968 он**

Гадаад хэлний мэдлэг:

**Англи, Орос**

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

**0930167**

### БОЛОВСРОЛ:

---

- 1985 -1992 онд Сибирийн өнгөт металын судалгааны хүрээлэнгийн их сургууль, Инженер

### АЖЛЫН ТУРШЛАГА:

---

- 1994 - 2000 онд Транс Уорлд Алюминиум компани, Нөөцийн газрын захирал
- 2001 - 2016 онд Чингис хаан банк, ТУЗ-ийн дарга
- 2004 - одоог хүртэл Монгол Даатгал ХК, ТУЗ-ийн дарга

## ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА



Эцэг /эх/-ийн нэр:

**Огай**

Өөрийн нэр:

**НАТАЛЬЯ ЮРЬЕВНА**

Төрсөн он: **1976 он**

Гадаад хэлний мэдлэг:

**Англи, Орос**

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

**0130813**

### **БОЛОВСРОЛ:**

---

- 1993 - 1998 онд Эрхүү хотын гадаад хэлний дээд сургууль, Хэл зүйч
- 2006 - 2009 онд Плехановын нэрэмжит Эдийн засгийн академи, Санхүүч

### **АЖЛЫН ТУРШЛАГА:**

---

- 2003 - 2005 онд Сибэкология, Худалдааны хэлтсийн дарга
- 2005 - 2016 онд Чингис хаан банк, Тусгай төслийн газар
- 2016 - одоог хүртэл Монгол Даатгал ХК, ТУЗ-ийн ажилтан

## ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА



Эцэг /эх/-ийн нэр:

**Ишхүү**

Өөрийн нэр:

**ДААРИЙМАА**

Төрсөн он: **1964 он**

Гадаад хэлний мэдлэг:

**Англи, Орос**

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

### БОЛОВСРОЛ:

---

- 2008 онд Мэргэшсэн эдийн засагч
- 1999 онд эдийн засгийн магистр
- 1986 онд МУИС-Эдийн засгийн сургууль-Эдийн засгийн бакалавр

### АЖЛЫН ТУРШЛАГА:

---

- 2004-2010 онд Сутайн буурлууд ХХК, Ерөнхий санхүүч
- 1988-2009 онд Говь ХК, Санхүүч, Эдийн засагч
- Блюскай Кашемир ХХК, Зөвлөх

## ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА



Эцэг/эх/-ийн нэр:

**Лизунова**

Өөрийн нэр:

**ТАНЯ**

Төрсөн он: **1983**

Гадаад хэлний мэдлэг:

**Англи, Орос**

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

**00279**

### **БОЛОВСРОЛ:**

---

- 1990 - 2000 онд ОХУ, ЭСЯ-ны дэргэдэх дунд сургууль Бүрэн дунд
- 2000 - 2004 онд МУИС Эдийн Засгийн Сургууль Банк санхүү бакалавр

### **АЖЛЫН ТУРШЛАГА:**

---

- 2006 - 2016 онд "Чингис Хаан" банк ТУЗ-ийн даргын туслах
- 2016 - одоог хүртэл Монгол Даатгал" ХК ТУЗ-ийн ажлын алба

## ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА



Эцэг /эх/-ийн нэр:

**Жамбал**

Өөрийн нэр:

**ЭРДЭНЭТУЯА**

Төрсөн он: **1981 он**

Гадаад хэлний мэдлэг:

**Англи, Орос**

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

### БОЛОВСРОЛ:

- 2000-2003 онд МУИС-Эдийн засгийн сургууль  
бакалавр
- 2010-2012 онд МУИС-Эдийн засгийн сургууль  
магистр

### АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2012-одоог хүртэл Алтан Дорнын Хүч ХХК,  
Гүйцэтгэх захирал

# ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА



Эцэг /эх/-ийн нэр:

**Энхсайхан**

Өөрийн нэр:

**АЛТАНЗУЛ**

Төрсөн он: **1987 он**

Гадаад хэлний мэдлэг:

**Англи**

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

## БОЛОВСРОЛ:

---

- 2006-2011 онд ХААИС Эдийн засгийн ухаан
- 2019-2020 онд ШУТИС Санхүүгийн удирдлага
- 2020-2022 онд СЭЗИС Бизнесийн удирдлага

## АЖЛЫН ТУРШЛАГА:

---

- 2025-одоог хүртэл Монгол Даатгал ХК Гүйцэтгэх захирал
- 2024-2025 Монгол Даатгал ХК Дотоод аудитор
- 2013-2024 Худалдаа Хөгжлийн банк Салбарын захирал

# ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ АНКЕТ



Эцэг /эх/-ийн нэр:

**Батмөнх**

Өөрийн нэр:

**МӨНХЗУЛ**

Төрсөн он: **1982 он**

Гадаад хэлний мэдлэг:

**Англи, Унгар, Хятад**

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

## БОЛОВСРОЛ:

- 2016-2016 онд Жоржтауны их сургууль, Санхүүгийн хөтөлбөр
- 2002-2008 онд Будапештийн Корвинус их сургууль, Эдийн засгийн бакалавр, мастер
- 2001-2002 онд Будапештийн Корвинус их сургууль, Мэргэжлийн Унгар хэл
- 1999-2001 онд Бээжингийн технологи, бизнесийн их сургууль, Хятад хэл
- 1998-1999 онд Техас, АНУ, Доби ахлах сургууль

## АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2021 - одоог хүртэл, Глобал Проспер ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- 2019-одоог хүртэл, Dochko's Bakery, Mongolia Central Mining ХХК-ийн үүсгэн байгуулагч
- 2021-2024 онд, Төслийн зохицуулагч (Тэтгэлэг 9208-МОН), Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, Азийн хөгжлийн банк
- 2017-2021 онд, Төслийн зохицуулагч, Дээд боловсролын шинэчлэл төсөл (Зээл 2766-МОН), Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Азийн хөгжлийн банк
- 2013-2015 онд, Төслийн зохицуулагч, "Бүх нийтийн боловсрол - Хурдан зам санаачлага" төсөл (Тэтгэлэг P108776) болон Боловсрол, бага насны хүүхдийн боловсролын төлөөх дэлхийн түншлэл (Тэтгэлэг P125445) Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Дэлхийн банк
- 2009-2012 онд, Төслийн зохицуулагч, Боловсролын салбарын шинэчлэл төсөл (Тэтгэлэг 0125-МОН), Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Азийн хөгжлийн банк
- 2008-2009 онд, НҮБХХ-ийн "Шударга ёс, хүний эрхийн хүртээмж" төслийн захиргаа, санхүүгийн ажилтан

# ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ АНКЕТ



Эцэг /эх/-ийн нэр:

**Наст**

Өөрийн нэр:

**ТЭМҮҮЛЭН**

Төрсөн он: **1983 он**

Гадаад хэлний мэдлэг:

**Англи, Орос**

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

## БОЛОВСРОЛ:

---

- 2007-2009 онд Олон улсын худалдаа, бизнес, Kangwon National University of South Korea
- 2001-2005 онд Эдийн засаг, Улаанбаатар дахь Г.В.Плехановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургуулийн салбар сургууль
- 1991-2001 онд Нийслэлийн 23 дугаар сургууль

## АЖЛЫН ТУРШЛАГА:

---

- 2022-одоог HCI LLC Гүйцэтгэх захирал
- 2015-2021 онд Оюу толгой прожект менежер

# “МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

№	Одоогийн мөрдөгдөж буй дүрмийн заалт	Оруулах нэмэлт, өөрчлөлт
1	7.22. Компанийн ТУЗ нь үйл ажиллагааныхаа үр өгөөжтэй, мэргэшсэн, хараат бус байдлыг хангах зорилгоор байнгын болон түр хороо байгуулж болно. ТУЗ нь Нэр дэвшүүлэх, Аудитын болон Цалин урамшууллын, Даатгалын хороотой байна. Эдгээр хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна. Харин Даатгалын хорооны гишүүд нь ТУЗ-ийн ердийн гишүүн байж болно.	7.22. Компанийн ТУЗ нь үйл ажиллагааныхаа үр өгөөжтэй, мэргэшсэн, хараат бус байдлыг хангах зорилгоор байнгын болон түр хороо байгуулж болно. ТУЗ нь Нэр дэвшүүлэх, Аудитын болон Цалин урамшууллын, Эрсдэл, даатгалын хороотой байна. Эдгээр хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна. Харин Эрсдэл, даатгалын хорооны гишүүд нь ТУЗ-ийн ердийн гишүүн байж болно.
2	7.45. Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой Нэр дэвшүүлэх, Аудитын болон Цалин урамшууллын хороотой байна. Эдгээр хороодын гишүүн нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна.	7.45. Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой Нэр дэвшүүлэх, Аудитын, Цалин урамшууллын болон Эрсдэл даатгалын хороотой байна. Эдгээр хороодын гишүүн нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна. Харин Эрсдэл, даатгалын хорооны гишүүд нь ТУЗ-ийн ердийн гишүүн байж болно.
3	7.52. ТУЗ нь даатгалтай холбоотой энэ зүйлд заасан үйл ажиллагааг Даатгалын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ. Даатгалын хороо нь дараах чиг үүрэгтэй байна.	7.52. ТУЗ нь даатгалтай холбоотой энэ зүйлд заасан үйл ажиллагааг Эрсдэл, даатгалын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ. Эрсдэл, даатгалын хороо нь дараах чиг үүрэгтэй байна.
4	7.53. Энэхүү дүрмийн 7.52-д заасан өндөр үнийн дүн, өндөр үнэлгээ болон компанийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий даатгалын гэрээ, Даатгалын нөхөн төлбөрийн асуудлыг Даатгалын хороо өөрөө тодорхойлно.	7.53. Энэхүү дүрмийн 7.52-д заасан өндөр үнийн дүн, өндөр үнэлгээ болон компанийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий даатгалын гэрээ, Даатгалын нөхөн төлбөрийн асуудлыг Эрсдэл, даатгалын хороо өөрөө тодорхойлно.
<b>Үндэслэл, тайлбар</b>		
2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар тус хорооны нэршлийг Эрсдэл, даатгалын хороо болгон өөрчилсөн. Хорооны нэршлийн өөрчлөлттэй уялдуулсан.		
5	8.1. ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий нягтлан бодогч нь компанийн эрх бүхий албан тушаалтан байна. Компанийн шийдвэр гаргалтад албан буюу албан бусаар оролцдог, компанийн толгой, хараат, охин болон зэргэлдээ компаниудын эрх бүхий албан тушаалтныг тус компанийн эрх бүхий албан тушаалтан гэж тооцох тухай шийдвэрийг ТУЗ гаргах эрхтэй.	8.1. ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, ерөнхий нягтлан бодогч нь компанийн эрх бүхий албан тушаалтан байна. Компанийн шийдвэр гаргалтад албан буюу албан бусаар оролцдог, компанийн толгой, хараат, охин болон зэргэлдээ компаниудын эрх бүхий албан тушаалтныг тус компанийн эрх бүхий албан тушаалтан гэж тооцох тухай шийдвэрийг ТУЗ гаргах эрхтэй.
<b>Үндэслэл, тайлбар</b>		
Дэд захирал гэсэн албан тушаалыг хасч, практикт нийцүүлсэн (КтХ 84.1).		
6	*Нэмэх заалт	7.32.23. “Ахмадын сан” байгуулах, мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох”
<b>Үндэслэл, тайлбар</b>		
Компанийн тухай хуулийн 16.2.8-д нийцүүлсэн. Компанийн тухай хуулийн 16.2. Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана: 16.2.8. “Ахмадын сан” байгуулах, мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох.		



## МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20 26 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 26111

Улаанбаатар хот

### Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд дүгнэлт өгөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.1, 96.5 дахь заалт, "Монгол Даатгал" ХК-ийн "Компанийн Дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн  
**ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг энэ тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Энэхүү дүгнэлтийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг тус хурлын даргад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ГРОМОВ С.Б.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ТЭСВИЙН САНАЛ

### THE EXPENDITURE BUDGET OF THE BOARD OF DIRECTORS FOR 2026

№	Зардлын зүйл ₮ Expenses ₮	Сарын цалин ₮ Monthly salary ₮	Нийт төсөв ₮ Total budget ₮
1	ТУЗ-ийн гишүүд Board members	792,000	47,520,000
2	ТУЗ-ийн дэргэдэх хроодын хурлын цалин Committees' meeting of the Board of Directors	100,000	4,000,000
3	Эчнээ санал хураалтын цалин External voting	200,000	6,000,000
4	ТУЗ-ийн хуралтай холбоотой бусад зардал Other expenses related to the Board meetings	3,000,000	3,000,000
<b>Нийт төсөв Total budget</b>		<b>60,520,000</b>	

"Монгол Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн 26/11 тоот тогтоолын хавсралт



## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2025 оны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэн танилцсаны үндсэн дээр "Монгол Даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс дараах дүгнэлтийг гаргаж танилцуулж байна.

### 1. Үндсэн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийн талаар

Монгол Улсын даатгалын салбарын зах зээл 2025 онд өсөлттэй хэвээр байгаа хэдий ч компанийн борлуулалтын гүйцэтгэл зах зээлийн өсөлтийн хурдаас тодорхой хэмжээгээр хоцорч, зах зээлд эзлэх хувь буурах хандлага ажиглагдаж байна. Тайлант хугацаанд компанийн цэвэр хураамжийн орлого жилийн төлөвлөгөөний **81 хувийн гүйцэтгэлтэй** биелсэн бөгөөд өмнөх оны мөн үеийн үзүүлэлттэй харьцуулахад буурсан байна.

Борлуулалтын сувгуудын гүйцэтгэлийг авч үзэхэд төлөвлөсөн түвшинд хүрээгүй, зарим сувгийн борлуулалтын хэмжээ буурсан нь компанийн зах зээл дэх байр суурь, борлуулалтын өсөлтөд нөлөөлсөн байна. Нөгөө талаас нөхөн төлбөрийн хэмжээ төлөвлөсөн түвшинд багтаж, даатгалын багцын хохирлын харьцаа харьцангуй тогтвортой хадгалагдсан нь багцын удирдлага болон эрсдэлийн бодлогын хэрэгжилтэд тодорхой ахиц гарсныг илтгэж байна.

### 2. Санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн талаар

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны журам болон санхүүгийн тайлагналын стандартын шаардлагад нийцүүлэн боловсруулж танилцуулсан байна.

Тайлант хугацаанд компанийн нийт хураамжийн орлого төлөвлөсөн хэмжээнд бүрэн хүрээгүй боловч нөхөн төлбөрийн хэмжээ төлөвлөгөөний хүрээнд хадгалагдаж, компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж ажилласан байна. Мөн андеррайтингийн бодлогыг баталж хэрэгжүүлсэн, даатгалын багцын эрсдэлийн удирдлагыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, үйл ажиллагааны зарим процессийг мэдээллийн технологид суурилан автоматжуулах ажлуудыг эхлүүлсэн нь компанийн дотоод удирдлага, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байна.

Цаашид Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, даатгалын салбарын өрсөлдөөн, зах зээлийн өөрчлөлтөд уялдуулан компанийн борлуулалтын бодлого, харилцагчийн үйлчилгээ, бүтээгдэхүүний үнэ тариф, багцын эрсдэлийн удирдлагыг оновчтой зохион байгуулж, зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардлын үр ашгийг сайжруулан ажиллах шаардлагатай гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс үзэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН  
ТӨСЛҮҮД**



**МОНГОЛ ДААТГАЛ**

**МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

20 **26** оны **04** сарын **30** өдөр

Дугаар **26101**

Улаанбаатар хот

**Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх  
Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.9 дэх заалт, “Монгол Даатгал” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн 7.8.1 дэх заалт, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.
2. 2026 онд Компанийн ашгийг нэмэгдүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ОДОНГЭРЭЛ



## МОНГОЛ ДААТГАЛ

### МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20 26 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 26102

Улаанбаатар хот

#### **Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт болон 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
2. Дараах 6 нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгосугай:
  1. ....
  2. ....
  3. ....
  4. ....
  5. ....
  6. ....
- Дараах 3 нэр дэвшигчийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгосугай:
  1. ....
  2. ....
  3. ....
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Т.Цацрал/-д даалгасугай.
5. Компанийн эрх ашгийг дээдлэн, Компанийн тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ОДОНГЭРЭЛ



## МОНГОЛ ДААТГАЛ

### МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20 26 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 26 /03

Улаанбаатар хот

#### Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.13 дахь заалт, “Монгол Даатгал” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн 7.8.5 дахь заалт, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Монгол Даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг тус тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төсвийг мөрдөн, ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг ТУЗ-ийн дарга /Громов С.Б./-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ОДОНГЭРЭЛ



**МОНГОЛ ДААТГАЛ**

**МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

20 26 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 26/04

Улаанбаатар хот

**Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.1 дэх заалт, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн .....дэх хэсэгт өөрчлөлт оруулж, ..... заалтуудад хавсралтад зааснаар нэмж оруулсугай.
2. Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Услын бүртгэлд бүртгүүлэхийг Үйл ажиллагааны газар Хуулийн албанд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ОДОНГЭРЭЛ

**“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН  
ТОГТООЛЫН ТӨСӨЛ**



## МОНГОЛ ДААТГАЛ

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

20 26 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 26/01

Улаанбаатар хот

#### Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйл 69.1 дэх заалт, 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, хурлын ирцийг бүртгэсэн дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт ..... хувьцааг эзэмшиж буй ..... хувьцаа эзэмшигч саналын хуудсаар саналаа ирүүлсэн нь нийт гаргасан энгийн хувьцааны ..... хувь болж байгааг хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4 дэх заалт болон компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтыг тус тус үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны ..... хувийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

КОМИССЫН ДАРГА

Х.ДОРЖЗОВД



## МОНГОЛ ДААТГАЛ

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

20 26 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 26102

Улаанбаатар хот

#### Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хуралд оролцогчдод мэдээлсүгэй:
  - 1.1 “Монгол Даатгал” ХК-ийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай нийт өгсөн саналын тоо ....., үүнээс татгалзсан ..., зөвшөөрсөн ....., нийт саналын эрхийн ..... хувийн саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсон.
  - 1.2 “Монгол Даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай нийт өгсөн саналын тоо ....., үүнээс татгалзсан ....., зөвшөөрсөн ....., нийт саналын эрхийн 100 хувийн саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсон.
  - 1.3 “Монгол Даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай нийт өгсөн саналын тоо ....., үүнээс татгалзсан 0, зөвшөөрсөн ....., нийт саналын эрхийн ..... хувийн саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсон.
  - 1.4 “Монгол Даатгал” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нийт өгсөн саналын тоо ....., үүнээс татгалзсан 0, зөвшөөрсөн ....., нийт саналын эрхийн ..... хувийн саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсон.

КОМИССЫН ДАРГА

Х.ДОРЖЗОВД



**МОНГОЛ ДААТГАЛ**  
SINCE 1934



**ТӨВ БАЙР:**

Түшиг төв, 1-р давхар,  
Сөүлийн гудамж, 4-р давхар,  
Улаанбаатар, Монгол Улс



**ЦАХИМ ХАЯГ:**

[www.mongolmaatgal.mn](http://www.mongolmaatgal.mn)  
[insurance@mongolmaatgal.mn](mailto:insurance@mongolmaatgal.mn)



**1800-1990**  
**ДААТГАЛЫН ЛАВЛАХ**